УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/221

Захиалагч:	Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар
Хянасан:	Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь
Удирдсан:	ПСХХ-ийн хэлтсийн дарга (Ph.D) Ц.Норовдондог
Судлаачид:	Д.Аюуш, Р.Нургүл, Р.Оргилмаа, Б.Уганжаргал

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

УДИРТГАЛ....2
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ХЭСЭГ....3
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ....5
НЭГ. МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ....5
ХОЁР. ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА....7
АМЕРИК....7
ГЕРМАН....11
НИДЕРЛАНД....14
БРИТАНИ....16
ГУРАВ. ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА....19
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ....24

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарын захиалгаар “Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалт: гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаарх Монгол Улсын болон гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Асуудлыг Монгол, Америк, Герман, Нидерланд, Британи зэрэг орны эрх зүйн орчны хүрээ, холбогдох хууль тогтоомж, практик үйл ажиллагааны туршлага болон олон улсын байгууллага, судалгааны төв, судлаач, эрдэмтдийн гаргасан гарын авлага, зөвлөмж болон эрдэм шинжилгээний өгүүлэл, материалын хүрээнд тус тус тоймлон судаллаа.

Судалгааны бүтэц: Судалгааны тайлан үндсэн 3 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, гэрч, хохирогчийг хамгаалах талаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын талаарх мэдээлэл, Хоёрдугаар хэсэгт, гэрч хохирогчийг хамгаалах талаарх гадаадын зарим орны туршлага, эрх зүйн орчин, Гуравдугаар хэсэгт, Үндэсний эрх зүйн зохицуулалт, бүтэц, үйл ажиллагааны талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: *Гэрч, хохирогчийг хамгаалах*

Key words: *Protection of victims and witnesses*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ХЭСЭГ

Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенцуудын тухайд: Монгол Улсын нэгдэн орсон хэд хэдэн олон талт олон улсын гэрээ, конвенцод гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой заалт, зохицуулалт буюу үүрэг тусгагдсан байна.

Тодруулбал, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчмын тухай тунхаглалд энэ талаарх зохицуулалт буюу үүргийг тусгасан байна.

Үндэсний эрх зүйн зохицуулалт, гэрч хохирогчийг хамгаалах нөхцөл байдлын тухайд: Монгол Улсад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, бусад холбогдох хууль тогтоомжоос бүрдэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан. Улмаар 2013 онд Монгол Улсын Их Хурлаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталсан. Тус хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон.

Бусад хууль тогтоомжийн хувьд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Төрийн болон албаны нууцын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд тус тус холбогдох зохицуулалт багтсан байна.

Гадаадын зарим орны гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын тухайд:

Хүснэгт 1. Улс орнуудын гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, харьяалах байгууллагын талаар харьцуулалт

Улс	Эрх зүйн орчин	Бүтэц
Америк	Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль (Organized Crime Control Act) 1970, Гэмт хэргийн хяналтын тухай хууль (Comprehensive Crime Control Act) 1984	Хууль зүйн яам (Department of Justice)-ны албад, харьяа холбооны хууль сахиулах, мөрдөн шалгах агентлаг, нэгжүүд гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг чиг үүрэгтээ багтаан хэрэгжүүлдэг байна.
Герман	Гэрчийг хамгаалах тухай хууль (Witness Protection Act) 1998, Эрсдэлтэй нөхцөлд буй гэрчүүдийн хамгаалалтыг уялдуулах тухай хууль (Act to Harmonize the Protection of Witnesses at Risk) 2001	Гэрчийг (хохирогчийг) хамгаалах тусгай байгууллага байхгүй бөгөөд энэ нь цагдаа, шүүхийн болон бусад холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгждэг байна.

Нидерланд	Гэрчийг хамгаалах тухай хууль (Witness Protection Act) 1994, Эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны тухай хууль (Dutch Criminal Code of Proceedings)	Гэрчийг болон хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тус хөтөлбөрийг Хууль зүйн яам хариуцан, прокурортой хамтарч ажилладаг.
Британи	Гэр бүлийн хүчирхийлэл ба гэмт хэргийн хохирогчийн хууль (Domestic Violence, Crime and Victims Act) 2004	Цагдаа, прокурор, шүүхээс гадна олон төрлийн төрийн бус байгууллагууд хохирогчдод туслалцаа үзүүлдэг.

Судалгаанд авагдсан орнуудын мэдээллийг нарийвчлан судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ

Монгол Улсын нэгдэн орсон хэд хэдэн олон талт олон улсын гэрээ, конвенцод гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой заалт, зохицуулалт буюу үүрэг тусгагдсан байна. Тодруулбал, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчмын тухай тунхаглалд тус тус энэ талаарх зохицуулалт буюу үүрэг тусгагдсан байна. Үүнд:

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, 1984 он[1]:

Конвенцын 13 дугаар зүйлд “оролцогч улс түүний нутаг дэвсгэрт эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна” гэж заасан.

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, 1998 он[2]:

Дүрмийн 68 дугаар зүйлд “Хохирогч ба гэрчийн хамгаалалт болон шүүх хуралдаанд тэдгээрийн оролцоо”-ны талаар зохицуулсан. Тодруулбал, 68 дугаар зүйлийн 1-6 дахь хэсэгт шүүх, прокурорын зүгээс гэрч, хохирогчийг хамгаалах үүргийг тусгасан. Үүнд, шүүх хохирогч болон гэрчүүдийн хувийн амьдралын аюулгүй байдал, бие махбодын болон сэтгэл санааны сайн сайхан байдал, нэр төр болон хувийн халдашгүй байдлыг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээ авна. Харин Прокурор ийм арга хэмжээг, ялангуяа эдгээр гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулахдаа авч хэрэгжүүлнэ. Ийм арга хэмжээ нь яллагдагчийн эрхэд хохирол учруулах буюу түүнтэй зөрчилдөх ёсгүй, түүнчлэн шударга болон нэг талыг бариагүй шүүх хуралдаан явуулахад хохирол учруулахгүй.

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол, 2000 он[3]:

Протоколын 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэрч, хохирогчийг хамгаалах талаар заасан бөгөөд оролцогч улсууд тус протоколоор хориглосон гэмт хэрэгт өртөж, хохирогч болсон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг эрүүгийн шүүн таслах бүх ажиллагааны үед дараах арга замаар хамгаалах талаар зохих арга хэмжээ авна гэж заасан. Үүнд:

- Гэмт хэрэгт өртөж хохирогч болсон хүүхдийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрч, тэдний онцгой шаардлага, ялангуяа гэрч болохынх нь хувьд тэдгээрийн онцгой шаардлагыг хүлээн зөвшөөрсөн журам батлах;
- Хохирогч болсон хүүхдэд тэдний эрх, үүрэг болон шүүн таслах ажиллагааны агуулга, хугацаа болон явц, уг хэргийн талаарх шийдвэрийн тухай мэдээлэх;

[1] Монгол Улс 2000 онд соёрхон баталж, 2002 оны 1 сарын 24-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
[2] Монгол Улс 2002 онд соёрхон баталж, 2002 оны 4 сарын 11-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
[3] Монгол Улс 2003 онд соёрхон баталж, 2003 оны 7 сарын 27-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.

- Шүүн таслах ажиллагааны явцад үндэсний хууль тогтоомжийн байцаан шийтгэх хэм хэмжээний дагуу хохирогч хүүхдийн санаа бодол, шаардлага болон асуудлыг тэдгээрийн хувийн ашиг сонирхол хөндөгдсөн үед танилцуулж, хэлэлцүүлэх боломж олгох;
- Шүүн таслах ажиллагааны явцад хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх;
- Шаардлагатай үед хохирогч хүүхдийн амь нас, нэр төрийг хамгаалах болон үндэсний хууль тогтоомжийн дагуу хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг зүй бусаар тараах явдлаас зайлсхийх арга хэмжээ авах.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, 2000 он[4]:

Конвенцын 25 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцод тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн тухайн тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийллээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна” гэж заасан.

Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчмын тухай тунхаглал[5], 1985 он:

Тус тунхаглалын 4 дүгээр зүйлд гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буюу бусад тохиолдолд гэрчийг хамгаалах талаар заасан. Түүнчлэн тус тогтоолын хавсралт болох Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчмын 14-17 дахь хэсэгт хохирогчид үзүүлэх туслалцааны асуудлыг тусгасан байна

[4] Монгол Улс 2008 онд соёрхон баталж, 2008 оны 6 сарын 27-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.
[5] Declaration of basic principles of justice for victims of crime and abuse of power.

ХОЁР. ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА

АМЕРИК

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Холбооны Засгийн газрын Хууль зүйн яам (Department of Justice)-ны албад, харьяа холбооны хууль сахиулах, мөрдөн шалгах агентлаг, нэгжүүд гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг чиг үүрэгтээ багтаан хэрэгжүүлдэг байна. Түүнчлэн төрийн бус байгууллагууд үндэсний хэмжээнд гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг давхар хэрэгжүүлж байна.

Нэгдсэн улсын хэмжээнд Холбооны Засгийн газрын Хууль зүйн яамны харьяа гэрчийг хамгаалах Маршалын алба /холбооны агентлаг/ (The Office of the United States Marshals), тус яамны Эрүүгийн газар (Criminal Division)-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба (Office of Enforcement Operations) [6] нь Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль (Organized Crime Control Act 1970) болон Гэмт хэргийн хяналтын тухай хууль (Comprehensive Crime Control Act 1984)-д заасны дагуу гэмт хэргийн гэрчийг хамгаалан, тэдэнд тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Мөн Холбооны Засгийн газрын Хууль зүйн яам, хууль сахиулах агентлагууд, Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах үндэсний төв (National Center for Victims of Crime), Гэмт хэргийн хохирогчдод туслах үндэсний хуульчдын холбоо (National Crime Victim Bar Association), Хохирогчдын өмгөөллийн үндэсний газар (National Organization for Victim Advocacy), Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох үндэсний нийгэмлэг зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд нь Гэмт хэргийн хохирогчийн эрхийн тухай хууль (Crime Victims' Rights Act 2004), Хохирогчийн эрх болон хохирлыг барагдуулах тухай хууль (Victims' Rights and Restitution Act 1990)-д тус тус заасны дагуу гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, тэдэнд тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна.

Эдгээр байгууллагуудаас АНУ-ын Хууль зүйн яам, хууль сахиулах зарим агентлагуудын гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны талаар авч үзлээ.

Хууль зүйн сайдын албанаас хэрэгжүүлдэг Гэмт хэргийн хохирогч, гэрчид туслах хөтөлбөр

АНУ-ын Хууль зүйн сайдын алба (US Attorney's Office)-аас Гэмт хэргийн хохирогч, гэрчид туслах хөтөлбөр (Victim Witness Assistance Program)-ийг хэрэгжүүлэн, гэмт хэргийг мөрдөх, шүүх явцад хохирогч, гэрчийг хамгаалах үйл ажиллагааг холбооны хууль сахиулах агентлагуудтай хамтран хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, Холбооны мөрдөх товчоо (Federal Bureau of Investigation), АНУ-ын Шуудангийн хяналт, шалгалтын газар (U.S. Postal Inspection Service), АНУ-ын Цагаачлал, гаалийн хяналтын газар (U.S. Immigration and Customs Enforcement) зэрэг болно. Түүнчлэн холбооны хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч, гэрчид эрүүгийн эрх зүйн процесс, түүнд оролцогч талуудын талаар болон хуулиар олгосон хохирогч, гэрчийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэл олгодог байна. Хөтөлбөрийн ажилтнууд шүүх хуралдааны явцад хохирогч болон гэрчийг хүсвэл хуралдаанд дагалдан орж болно.[7]

<u>Гэрчийг хамгаалах Маршалын алба</u>

АНУ-ын Маршалын алба нь 1789 онд анх байгуулагдсан бөгөөд одоогийн хууль хэрэгжүүлэгч агентлаг (United States Marshals Service) нь 1969 онд байгуулагдсан байна. Маршалын алба нь Хууль зүйн яаманд харьяалагддаг бөгөөд тус яамны сайд (Attorney General)-ын удирдлаган дор нэгдсэн улсын 94 шүүхийн тойрогт салбартайгаар үйл

[6] https://www.justice.gov/criminal/criminal-oeo
[7] https://www.justice.gov/usao-cdca/programs/victimwitness-assistance-program

ажиллагаагаа явуулдаг. АНУ-ын Ерөнхийлөгч шууд томилдог Маршалууд (US Marshals) буюу мэргэшсэн экспертүүд нь эдгээр 94 шүүхийн тойргийн хууль хэрэгжүүлэх салбар байгууллагуудыг удирддаг бөгөөд 3700 гаруй Дэд Маршалууд болон Эрүүгийн мөрдөн байцаагчид агентлагийн гол үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Маршалын алба нь холбооны хууль, шүүхийн тогтолцоонд онцгой үүрэгтэй бөгөөд холбооны шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба юм.

Холбооны хууль сахиулах бүхий л төрлийн үйл ажиллагаанд оролцоотой байдаг Маршалын алба нь холбооны шүүхийг хамгаалах, холбооны оргон зугтаагчийг баривчлах, хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгтнүүдийн хөрөнгийг хураах, зарж борлуулах, улсын орлого болгох үйл ажиллагааг зохион байгуулах, холбооны хоригдлуудыг цагдан хорих, тэднийг тээвэрлэх, хорих ангид хүргэх зэрэг үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангах, Гэрчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэдэг байна.

Маршалын албанаас Нэгдсэн улсын хэмжээнд хэрэгжүүлдэг Гэрчийг хамгаалах хөтөлбөр (Witness Security Program)-ийг Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль (Organized Crime Control Act 1970) болон Гэмт хэргийн хяналтын тухай хууль (Comprehensive Crime Control Act 1984)-д тус тус заасны дагуу хэрэгжүүлж эхэлсэн байна.

Гэрчийг хамгаалах хөтөлбөрөөр томоохон, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, тэдгээрийн гишүүд, тухайлбал, террорист бүлэглэлийн гишүүд, гэмт хэрэгтнүүдийг гэрчлэх, тэдгээрийн эсрэг мэдүүлэг өгөх гэрчүүдийг хамгаалалтанд авдаг байна. Тодруулбал, АНУ-ын Засгийн газартай хамтран ажилласны улмаас амь нас нь эрсдэлд ороод байгаа гэрчүүд болон тэдгээрийн хамаарал бүхий гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэдэг. 1971 оноос 2023 оны 10 сарыг хүртэл гэм зэмгүй хохирогч-гэрч, шүүгдэгч болон тэдгээрийн хамаарал бүхий гэр бүлийн гишүүд, нийт 19.100 хүнийг айлган сүрдүүлэх, залхаан цээрлүүлэх аюулаас хамгаалах үйлчилгээ үзүүлсэн байна. Маршалын алба нь хэргийг шүүх ажиллагаа болон шүүхэд ирж мэдүүлэг өгөх зэрэг онц аюултай нөхцөл байдалд 24 цагийн турш гэрчийг хамгаалах үйлчилгээ үзүүлдэг.

Гэрч нь нэн тэргүүнд орон байр, амьжиргааны зардал, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдахад шаардлагатай санхүүгийн тусламжид хамрагддаг. Түүнчлэн гэрчүүд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд шинээр биеийн байцаалт олгодог байна. Гэрчийг хамгаалах хөтөлбөрт хамрагдан, хөтөлбөрийн удирдамжийг баримтлан, хамгаалагдаж байсан нэг ч гэрч гэмтэж бэртэн, амь насаа алдаж байгаагүй байна.

Маршалын албаны гэрчийг хамгаалах асуудлаар тэргүүлэх, мэргэшсэн, туршлагатай, экспертүүд Гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд дэлхийн бусад улс орнуудын хууль хэрэгжүүлэгч байгууллагад ажилладаг төрийн албан хаагчдад гэрчийг хамгаалах асуудлаар сургалт явуулж, заавар зөвлөгөө өгдөг байна.

Гэрчийг хамгаалах хөтөлбөрөөс салбарласан, иргэний болон эрүүгийн гэмт хэргийг шүүх, түүнчлэн бусад үйл ажиллагааны үеэр гэрчүүдэд яаралтай тусламж үзүүлэх **Гэрчийн яаралтай тусламжийн хөтөлбөр** (Emergency Witness Assistance Program)-ийг 1997 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.[8] Тус хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлдэг бөгөөд гэмт хэргийн гэрч нь тодорхой үйл ажиллагаан дээр Засгийн газартай хамтран ажиллахаар тохиролцохын өмнө, эсхүл дараа нь богино хугацаанд тодорхой хэмжээний амьжиргааны зардал олгон, гэмт хэргийн айдас, түгшүүрийг арилгах зэрэг үйлчилгээнд хамруулдаг байна.

Хууль зүйн сайдын албанаас хэрэгжүүлдэг Гэрчийн яаралтай тусламжийн хөтөлбөр нь богино хугацаанд гэрчүүдэд туслалцаа үзүүлэх зорилгынхоо хүрээнд муж, орон нутагт мөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байна. Тус хөтөлбөр нь гэрчүүдэд нэн даруй шаардлагатай байгаа

[8] https://oig.justice.gov/reports/EOUSA/e0102/index.htm

тусламжийг үзүүлэн, холбооны хэмжээнд явагдаж буй гэмт хэргийн мөрдлөгөд тэдгээрийг оролцуулах, хямд өртөгтэй хөтөлбөр юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага нь дараах төрлийн тусламж, үйлчилгээг ихэвчлэн 30 хоногийн дотор, 4000 ам.долларт багтаан үзүүлдэг байна. Үүнд:

- Тээврийн зардал;
- Түр хугацаанд байрлах, нүүн очих зардал;
- Амьжиргааны зардал;
- 250 хүртэлх ам.долларын бусад зардал;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болон холбогдох бусад ажилтантай холбоо барих хөдөлгөөнт утас (гар утас)-ны зардал;
- Гэрчийн хамаарал бүхий хүүхэд болон өндөр настны асаргааны зардал зэрэг болно.

Хууль зүйн яамны харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны чиг үүрэгт Гэрчийг хамгаалах хөтөлбөрт хамрагдахаар хүсэлт гаргасан гэрчүүдийн хүсэлттэй танилцаж, зөвшөөрөх болон татгалзах, хөтөлбөртэй холбоотой аливаа үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, холбооны агентлагуудаас холбооны шоронд хоригдож буй ялтнуудыг гэмт хэргийн мөрдлөгөд ашиглахаар тавьсан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх зэрэг үйл ажиллагаа багтдаг байна.

<u>Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах алба</u>

АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах ажлын хэсэг (President’s Task Force on Victims of Crime)-ээс гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс 1983 онд Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах алба (Office for Victims of Crime)-ыг байгуулсан байна. Тус алба нь дараах зургаан хэлтэстэй. Үүнд,

- Үйл ажиллагаа, төсөв, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс;
- Бодлого, харилцаа холбооны хэлтэс;
- Мужийн гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах хэлтэс;
- Овог аймгийн гэмт хэргийн хохирогчид (Tribal victims)-ыг хамгаалах хэлтэс;
- Хүний наймааны гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах хэлтэс;
- Хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэлтэс болно.

Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах алба нь гэмт хэргийн хохирогчдын талаар хэрэгжүүлж буй үндэсний хэмжээний олон төрлийн хөтөлбөрүүдийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй байна. Голлох хөтөлбөрүүдээс дурдвал:

- Хохирогчдод тусламж үзүүлэх, нөхөн төлбөр олгох удирдах ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, техник тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх хөтөлбөр;
- Гэмт хэргийн хохирогч болсон Индиан болон Аляскийн уугуул иргэдийг хамгаалах хөтөлбөр;
- Хүний наймааны гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах хөтөлбөр;
- Гэмт хэргийн хохирогч өндөр настныг хамгаалах хөтөлбөр;
- Хууль сахиулагчдад гэмт хэргийн хохирогчтой хэрхэн харилцах, тусламж үзүүлэх талаар мэдлэг, мэдээлэл олгох хөтөлбөр;
- Америкчуудын эсрэг дотоодын болон олон улсын терроризм, олон нийтийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод тусламж үзүүлэх хөтөлбөр;
- Терроризмын эсрэг яаралтай тусламжийн хөтөлбөр;
- Олон улсын терроризмын хохирогчдод нөхөн төлбөр олгох хөтөлбөр;

- “Үндэсний гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах долоо хоног” хөтөлбөр зэрэг болно.[9]

Гэмт хэргийн хохирогчдын тухай хууль (Victims of Crime Act)-ийн 1984 оны нэмэлт өөрчлөлтөөр Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах алба нь 1988 оноос Гэмт хэргийн хохирогчдод туслах сан (Crime Victims Fund)-г удирдах, захиран зарцуулах эрхтэй болжээ.

Гэмт хэргийн хохирогчдод туслах санг татварын мөнгөөр бус нэгдсэн улсын хэмжээнд гарсан зөрчил, гэмт хэрэгт ногдуулсан торгууль, хувийн өмчийн тусгай татвар, хураагдсан бонд зэргээр бүрдүүлдэг байна. Тус сан нь жил бүр үндэсний хэмжээнд буюу бүх муж, газар нутгийг хамран гэмт хэргийн улмаас бие махбод, сэтгэл санаа болон санхүүгийн хохирол амссан хохирогчдыг хамгаалах, тэдэнд нөхөн олговор олгох, тусламж үзүүлэх зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж буй олон тооны, өргөн хүрээний хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг байна. Хөтөлбөрт гэмт хэргийн шууд үр дагаврыг арилгах, хэвийн амьдралдаа эргэн ороход нь хохирогчдод дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа багтдаг. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах, техник, тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх, мэдээ, мэдээллээр хангах зэрэгт санхүүжилт олгодог байна.

Конгрессоос олгосон эрхийн дагуу Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах алба нь Гэмт хэргийн хохирогчдод туслах сангийн хөрөнгийг дахин хуваарилж байгуулсан “Овог аймгийн гэмт хэргийн хохирогчдод туслах хөтөлбөрийг хэрэгжүүлэх сан”-г удирдан ажилладаг байна.

Холбооны мөрдөх товчооны Хохирогчдыг хамгаалах хэлтэс

Холбооны мөрдөх товчооны Хохирогчдыг хамгаалах хэлтэс нь тус товчооноос мөрдсөн гэмт хэргийн хохирогчдыг хуульд болон Хохирогч, гэрчид тусламж үзүүлэх тухай Хууль зүйн сайдын албанаас гаргасан гарын авлага (Attorney General Guidelines on Victim and Witness Assistance)-д заасны дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байна.

2001 оноос Холбооны мөрдөх товчооны хохирогчдод тусламж үзүүлэх хөтөлбөрүүдөөр 2 сая гаруй гэмт хэргийн хохирогчдод гэмт хэргээс үүдэлтэй айдас түгшүүрээс ангижрах, яаралтай сэлгэн суурьших, орон нутгийн салбараас зөвлөгөө авах, орон байраар хангах болон бусад төрлийн тусламж үйлчилгээг үзүүлсээр ирсэн байна.[10]

Хууль зүйн яамны Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах Омбудсмэний алба

Хууль сахиулах байгууллагын ажилтнууд нь Гэмт хэргийн хохирогчийн эрхийн тухай хуульд заасны дагуу хохирогчийн эрхийг хангаж, хамгаалж ажиллах үүрэгтэй. Харин Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах Омбудсмэний алба (Office of the Victims’ Rights Ombuds)-ны ажилтнууд нь хуульд заасан хохирогчийн эрхийг зөрчсөн, эсхүл хангаагүй гэх үндэслэлээр Хууль зүйн яамны ажилтнуудын эсрэг хохирогчийн талаас гаргасан гомдлыг хүлээн авч, мөрдөн шалгаж, асуудлыг шийдвэрлэдэг байна. Омбудсмэний албанаас тухайн ажилтныг шалган, гэмт хэргийн хохирогчийн хуулиар олгогдсон эрхийг хангаж ажиллаагүй буруутай гэж үзсэн тохиолдолд ажилтныг гэмт хэргийн хохирогчийн эрхийн тухай сургалтанд суухыг шаардах, түүнчлэн сахилгын хариуцлага тооцохыг холбогдох удирдлагаас шаарддаг байна.

[9] https://ovc.ojp.gov/programs
[10] https://www.fbi.gov/how-we-can-help-you/victim-services

ГЕРМАН

Гэрчийг хамгаалах хөтөлбөр

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Герман)-д 1980-аад оны дунд үеэс гэрчийг хамгаалах хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийг анх тус улсын Гамбург хотод мотоциклийн бүлэглэлтэй холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх үеэр ашиглаж байжээ. Түүнээс хойш Германы Холбооны эрүүгийн цагдаагийн алба болон мужуудын цагдаагийн алба системтэйгээр хэрэгжүүлэх болсон байна. Гэрчийг хамгаалах хөтөлбөрүүд нь эрүүгийн хэрэг, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм, хүний наймаа зэрэг ноцтой гэмт хэрэгт чухал мэдүүлэг өгсөн хүмүүсийг хамгаалах, гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн эрх, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангахад чиглэгдсэн цогц бөгөөд олон талт үйл ажиллагаа юм (Германд эрүүгийн гэмт хэрэгт өртсөн хүмүүс мэдүүлэг өгөхдөө гэрчээр тооцогддог учраас тэд бусад гэрчтэй адил эрх, үүрэгтэй байна[11]).

1998 онд **Гэрчийг хамгаалах тухай хууль** (Witness Protection Act) батлагдсан бөгөөд хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад эрсдэлтэй бүлгийн гэрчүүдээс (ялангуяа хохирогчоор мэдүүлэг өгч буй хүүхдүүд) ярилцлага авахад видео технологи ашиглах; эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд гэрчийн хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах боломжоор хангах; хохирогч, гэрч нарт хууль зүйн туслалцаа үзүүлэх гэх мэт гэрчтэй холбоотой харилцааг зохицуулах чухал заалтуудыг оруулжээ.[12] Түүнчлэн мэдүүлэг өгснөөр эрсдэлд орж болзошгүй гэрчийг хамгаалах арга хэмжээнүүдийг хуульд тусгасан байна. Үүнд:

- Хувийн мэдээллийн нууцлал: Гэрчийн хэн болохыг нууцалж, шүүх хуралдааны явцад тэдний аюулгүй байдлыг хангах тусгай арга хэмжээ авах;
- Хамгаалалтын тусгай арга хэмжээ: Аюул заналхийллийн түвшнээс хамааран өөр өөр төрлийн хамгаалалтын арга хэмжээ авах, тухайлбал, гэрчийг биечлэн хамгаалах хүмүүсээр хангах гэх мэт;
- Хууль сахиулах байгууллагын оролцоо: Гэрчид учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, шүүх ажиллагааны явцад шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын гүйцэтгэх үүргийн талаар;
- Дэмжих үйлчилгээ: Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд мэдүүлэг өгөхтэй холбоотой сэтгэл зүйн дарамтыг даван туулахад нь гэрчид сэтгэл зүйн дэмжлэг болон хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Гэрчийг хамгаалах хөтөлбөрүүд: Өндөр эрсдэлтэй тохиолдолд гэрчийг хамгаалах хөтөлбөрт хамруулж, аюулгүй байдлыг хангах, нүүлгэн шилжүүлэх талаар цогц тусламж үзүүлэх зэрэг болно.

Мөн түүнчлэн 1998 онд Холбооны эрүүгийн цагдаагийн албанаас гэрчийг хамгаалах үзэл баримтлалыг боловсруулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хэрэгжүүлэх зорилго, арга хэмжээг анх удаа тодорхойлсон байна.

Энэ хүрээнд холбооны болон мужуудын дотоод хэрэг, хууль зүйн яамдаас эрсдэлтэй гэрчүүдийг хамгаалах ерөнхий удирдамжийг гаргасан бөгөөд энэхүү удирдамж нь тус улсын гэрчийг хамгаалах хөтөлбөрийн үндсэн суурь болж байв.

[11] Rights and obligations of witnesses, https://www.hilfe-info.de/Webs/hilfeinfo/EN/KnowYourRights/HilfeUndRechte/witnesses/RechteUndPflichten/RechteUndPflichten_node.html#:~:text=In%20certain%20cases%2C%20witnesses%20may,or%20relatives%20by%20doing%20so.

[12] Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime, United Nations Office on Drugs and Crime, Vienna., https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf

2001 онд **Эрсдэлтэй нөхцөлд буй гэрчүүдийн хамгаалалтыг уялдуулах тухай** хууль (Act to Harmonize the Protection of Witnesses at Risk) батлагдсан бөгөөд 2003 онд дээрх удирдамжийг тус хуулийн заалттай нийцүүлэн боловсруулсан байна. (Одоо удирдамж нь гэрчийг хамгаалах чиглэлээр ажилладаг бүх газруудад хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хэрэглэгдэж байна).

Эрсдэлтэй нөхцөлд буй гэрчүүдийн хамгаалалтыг уялдуулах тухай хуулийг холбооны болон муж улсын түвшинд гэрчийг хамгаалах эрх зүйн нөхцөл, шалгуурыг уялдуулах зорилгоор нэвтрүүлсэн бөгөөд хуульд дараах үндсэн зохицуулалтуудыг тусгажээ. Үүнд:[13]

- Хөтөлбөрт хамрагдах гэрчүүдийн ангилал, гэрчийг хамруулах болон хасах шалгуур. Тухайлбал, хуулийн дагуу хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн талаар мэдүүлэг өгөх болсноор аюул, эрсдэлд орсон хүмүүсийг хамруулах шалгуур гэх мэт.
- Шийдвэр гаргах, хэрэгжүүлэх эрх мэдэл. Хуульд заасны дагуу гэрчийг хамгаалалтад авахдаа хамгаалалтын нэгж болон улсын прокурор хамтран шийдвэр гаргахаар заасан байдаг ч тухайн гэмт хэрэг хэр зэрэг хүнд, түүнчлэн эрсдэлийн хэмжээ, яллагдагчийн эрх, бусад арга хэмжээний үр нөлөө зэргийг харгалзан гэрчийг хамгаалах нэгж нь бие даан шийдвэр гаргах эрх мэдэлтэй байхаар зохицуулсан байна.
- Гэрчийг хамгаалах албад, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамгаалалтад байгаа гэрчийн хувийн мэдээллийн нууцлал. Хамгаалалтад байгаа гэрчийн хавтаст хэргийг хамгаалалтын алба хөтөлдөг бөгөөд түүнийг мөрдөн байцаалтын явцад хавтаст хэрэгт оруулдаггүй боловч хүсэлтийн дагуу прокурорт өгөхөөр тусгажээ.
- Биеийн байцаалт, хувийн баримт бичиг олгох нөхцөл, хамгаалалтад байх хугацаанд олгох тэтгэмжийн талаар тус тус зохицуулсан байна.

Эдгээр арга хэмжээ гэрчийг өөрт нь ирэх дарамт, аюул заналхийлэл, эрсдэлээс айхгүйгээр мэдүүлэг өгөхөд дэмжлэг болох зорилготой бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах ажиллагаа, шүүх засаглал болон нийгмийн шударга ёсыг дэмжихэд чухал ач холбогдолтой гэж үздэг.

Гэрч, хохирогчийг хамгаалах байгууллагууд

Германд гэрчийг (хохирогчийг) хамгаалах тусгай байгууллага байхгүй бөгөөд энэ нь цагдаа, шүүхийн болон бусад холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгждэг байна.

Гэрчийг (хохирогчийг) хамгаалах хөтөлбөрийг Холбооны эрүүгийн цагдаагийн алба удирддаг бөгөөд мужийн цагдаагийн албад нь гэрчийг хамгаалахад тус албатай хамтран ажилладаг.

Холбооны Эрүүгийн цагдаагийн алба нь гэрчийг (хохирогчийг) хамгаалах хүрээнд үндэсний болон олон улсын түвшинд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гэрчийг (хохирогчийг) хамгаалах хөтөлбөрийн жилийн тайлан бэлтгэх;
- Сургалт, мэдлэг, мэдээлэл олгох ажлыг тасралтгүй зохион байгуулах;
- Холбооны болон мужуудын гэрчийг хамгаалах албаны дарга нарыг оролцуулсан хурлыг тогтмол зохион байгуулах;
- Гадаадад байрладаг холбооны болон мужын агентлагууд, байгууллагуудын хамтын ажиллагааг хариуцан ажиллах;

[13] Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime, United Nations Office on Drugs and Crime, Vienna., https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf

- Олон улсын хамтын ажиллагааг хангах.

Германд “Холбооны улсын гэрчийг хамгаалах ажлын чанарын баталгаажуулалтын төслийн бүлэг” (Federal State Project Group on Quality Assurance in the Field of Witness Protection) ажилладаг. Энэ нь 7 мужийн гэрч хамгаалах албаны захирлуудаас бүрдсэн байх бөгөөд түүнийг Холбооны эрүүгийн цагдаагийн алба удирдана. Энэхүү бүлэг нь улсын хэмжээнд гэрчийг хамгаалах хөтөлбөрт хамруулах журмыг боловсруулж, үр дүнтэй хамтын ажиллагаагаар хангах, мөн хөтөлбөрт хамрагдах гэрч болон гэрчийг хамгаалах албаны ажилтнуудад тавигдах стандарт шаардлага, сургалт, мэдлэг боловсролоор тасралтгүй хангах талаарх нийтлэг үзэл баримтлалыг бий болгох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Түүнээс гадна гэрч, хохирогчийг хамгаалахад дараах байгууллагууд оролцдог. Үүнд:

- **Хууль хяналтын байгууллага**: Цагдаа, прокурорын газар зэрэг байгууллагууд орно. Хууль хяналтын байгууллагууд гэрч, хохирогчдыг хамгаалах, мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилгоор хамтран ажилладаг.
- **Судалгааны байгууллагууд**: гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах, мэдээ, мэдээллээр хангах болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагууд, нийгмийн ажилтнууд болон бусад мэргэжилтнүүд мөн хамтран ажилладаг.
- **Сэтгэл заслын байгууллагууд**: гэрч, хохирогчид сэтгэл зүйн дэмжлэг авах шаардлагатай бол сэтгэл заслын мэргэжилтнүүд, тухайлбал сэтгэл зүйчид дэмжлэг үзүүлдэг.
- **Бусад байгууллагууд**: гэрч, хохирогчийг хамгаалах талаар хууль зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд оролцдог.

Эдгээр байгууллагууд хоорондоо харилцан хамтарч ажиллах бөгөөд гэрч, хохирогч болон тэдний эрхийг хамгаалах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ

Германд гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөр нь цагдаагийн байгууллага, шүүхийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаатай хэрэгждэг. Хуулийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд:

1. **<u>Гэрчийг хамгаалах:</u>** Гэрчийг хамгаалах зорилгоор цагдаагийн байгууллагаас хамгаалалтын арга хэмжээ авах боломжтой. Энэ нь гэрчийг гэмт хэрэгтнээс хамгаалах, шууд заналхийлэлд өртөхөөс сэргийлнэ.
2. **<u>Хувийн мэдээллийг нууцлах:</u>** Гэрчийн мэдээллийг нууцлах, үүнд шаардлагатай бол түүний нэр, холбоо барих мэдээллийг нууцалж болно. Зарим тохиолдолд гэрчийн оролцоог хуулиар хамгаалж, шүүхийн өмнө нэрийг нь нууцалж болдог.
3. **<u>Аюулгүй байдлыг хангах</u>**: Хэрэв гэрчийн аюулгүй байдлыг урьдчилан таамаглах боломжтой бол түүнийг хамгаалах зорилгоор нүүлгэн шилжүүлэх, аюулгүй газар байрлуулах зэрэг арга хэмжээ авна. Гэрчийг өөр хот, эсвэл бүс рүү, онцгой тохиолдолд өөр улс руу шилжүүлж болно.
4. **<u>Дэмжлэг үзүүлэх</u>**: Хохирогчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээлэл, хууль зүйн зөвлөгөө, эмчилгээний үйлчилгээгээр хангах зэрэг дэмжлэг авахад чиглэсэн олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

5. **<u>Шүүх ажиллагааны үеэр авах арга хэмжээ</u>**: Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд шүүхийн процессын явцад тодорхой зохицуулалтууд хийгддэг. Жишээлбэл, гэрчийг шүүхэд видео технологи ашиглан оролцуулах, мөн хохирогчийн тайван байдал, аюулгүй байдлыг хангахын тулд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт.

<u>Хамгаалалтын хугацаа:</u> Гэрчийг хамгаалах хугацаа нь аюул занал, эрсдэлийн хэмжээнээс хамааран янз бүр байж болох ба шүүх хурлын үргэлжлэх хугацааны туршид болон түүнээс олон жил үргэлжилж болно.

НИДЕРЛАНД

Нидерланд улсад гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт нь Эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны тухай хууль[14] болон Гэрчийг хамгаалах тухай хуулийн[15] хүрээнд хэрэгждэг байна. Үүнд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн холбогдох хэсэгт заасан бол гэрчийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тус хууль болон Гэрчийг хамгаалах тухай хуульд тусгасан байна.

Мөн тус улсын гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчид аюул учрахаас сэргийлэх зорилгоор тэдний нэр, хувийн мэдээллийн талаарх нууцлалыг хангахад анхаарч, энэ талаар зохицуулалтыг нарийвчлан заасан онцлогтой байна. Өөрөөр хэлбэл гэрч, хохирогчийг хамгаалах эхний буюу үндсэн арга хэмжээ нь нэр, мэдээллийг нууцлах арга хэмжээ байна.

Нэр, мэдээлэл нууцалсан гэрчийн хэн болох нь шүүгдэгч болон өмнө нь гэрчийг заналхийлсэн бусад этгээдэд мэдэгдвэл ямар арга хэмжээ авах нь Гэрч хамгаалах үндэсний хөтөлбөр болон Хохирогч хамгаалах үндэсний хөтөлбөрийн зорилгод хамаарна. Ерөнхийдөө ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд цагдаа, шүүхийн байгууллага түр арга хэмжээ авах зарчим тус улсад хэрэгждэг байна. Тухайлбал, гэрчийг түр нуугдахад нь туслах бөгөөд энэ хугацаанд холбогдох хамгаалах хөтөлбөрт хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.

Гэрчийг хамгаалах талаар:

Тус улсын хувьд өмнө дурдсанчлан гэрчийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчид аюул учрах магадлалтай нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрчийн талаарх мэдээллийг нууцлах, шүүгдэгчтэй уулзах, харилцахаас сэргийлэх байдлаар гэрчийг аюулаас хамгаалах чиглэлд голчлон анхаарч, энэ талаарх зохицуулалтыг нарийвчлан тогтоосон онцлогтой.

Тодруулбал, тус улс 1994 онд "Гэрчийг хамгаалах тухай" хууль баталсан байна. Энэхүү хууль гарахаас өмнө Улсын дээд шүүх нэрээ нууцалсан гэрчийн мэдүүлгийг эрүүгийн хэрэгт нотлох баримт болгон ашиглаж болох нөхцөлүүдийг тодорхойлох зэрэг зохицуулалт үйлчилдэг байсан бөгөөд эдгээр нөхцөлүүдийн ихэнх нь Гэрчийг хамгаалах тухай хуульд тусгалаа олсон байна. Ингэхдээ нэрээ нууцалсан гэрчүүдийг гурван өөр ангилалд ерөнхийд нь хуваасан байна.

Эхний ангилалд мэдүүлэг өгөхтэй холбоотой асуудал үүсэх магадлалтай эсвэл цаашид мэргэжлээрээ ажиллахад нь саад учирч болзошгүй гэсэн үндэслэл бүхий гэрчүүд багтана. Үүнд, тухайлбал нэр, албан тушаалаа нууцлан ажиллаж байхдаа яллагдагчтай уулзсан цагдаа багтана. Ийм төрлийн гэрчүүдэд нэрээ нууцлах эрхийг хязгаарлагдмал байдлаар олгож,

[14] Dutch Criminal Code of Proceedings (Wetboek van Strafvordering).
[15] Witness Protection Act

тэднийг шалгагч магистрат[16] эсвэл анхан шатны шүүх хаалттай сонсоно. Мөн энэ тохиолдолд шүүгч гэрчийн талаарх мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй бөгөөд түүний хувийн мэдээллийг задруулахгүй байх талаар арга хэмжээ авна[17].

Хоёр дахь ангилалд амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, гэр бүлийн амьдрал, нийгэм, эдийн засгийн нөхцөлд байдалд нь аюул учрах эрсдэлтэй гэрчүүд багтана. Ийм тохиолдолд шалгагч магистрат гэрчид нэрээ бүрэн нууцлах боломж олгоно. Өөрөөр хэлбэл, шүүхэд гэрчийн мэдүүлгийг гэрчийн хэн болохыг бүрэн нууцалсан байдлаар авна. Ингэхдээ шүүгдэгч, түүний өмгөөлөгч эсвэл хоёуланг нь мэдүүлэг авах шүүх хуралдаанд оролцохыг хориглож болно. Мөн өмгөөлөгчийг оролцуулахгүй тохиолдолд Улсын яллагчийг ч байлцуулахгүй байх шийдвэр ч гаргаж болно.

Энэ тохиолдолд шүүгдэгч, түүний өмгөөлөгч, улсын яллагч нарт асуухыг хүссэн асуултаа утсаар эсвэл бичгээр өгөх боломжийг олгодог байна. Асуулт асуухдаа магистрат өөрийн ажлын байранд нууцлалтай явуулах бөгөөд мэдүүлэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны нотлох баримт болон ашиглагдана.

Гурав дахь ангилалд нэр нь үл мэдэгдэх, цагдаагийн мэдүүлэгт бичигдсэн ч хэн болохыг нь бичээгүй байцаасан гэрчүүд багтана. Ийм төрлийн нэр нь бүрэн нууцлагдсан гэрчүүдийн хувьд мэдүүлгийг нотлох баримт болгон ашиглахад нийт гурван шаардлага тавигдана. Нэгдүгээрт, шалгагч магистрат гэрчийг заналхийлэлд өртсөн гэрч гэж тодорхойлох ёстой. Хоёрдугаарт, тухайн хэрэг нь цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ шаарддаг хүнд гэмт хэрэг байх ёстой. Гуравдугаарт, шүүгч зөвхөн нэрээ нууцалсан гэрчүүдийн мэдүүлэгт үндэслэн шүүгдэгчийг гэм буруутай гэж үзэж болохгүй гэсэн нөхцөл тавьсан байна. Гэрчийн нэрийг бүрэн нууцлах эсэхийг шалгагч магистрат шийднэ.

Процессын хувьд анхан шатны шүүгч гэрчийн нэрийг нууцлах шаардлагатай эсэх талаар шалгалт явуулахыг шалгагч шүүгч буюу магистратад тушааж болно. Ингэхдээ гэрчийн нэрийг нууцлах талаар шийдвэр гаргахын өмнө шүүгдэгч, түүний өмгөөлөгч, гэрчийг сонсох боломжийг олгоно. Холбогдох гэрчийн нэрийг бүрэн нууцлах шийдвэрийг давж заалдаж болох бөгөөд гурван шүүгчээс бүрдсэн бүрэлдэхүүн давж заалдах хүсэлтийг шийдвэрлэнэ.

Гэрчийн нэрийг нууцлах ажиллагаа практикт ихэвчлэн гэрчийг өмгөөлөгч болон улсын яллагчаас тусгаарлаж, гэрчээс байцаалт авах ажиллагаа нь нууц байрлалд явагдах, эцсийн мөч хүртэл өмгөөлөгчөөс нууцлагдсан цагт явагдах зэрэг хэлбэрээр хэрэгждэг байна.[18]

Нидерландад гэрчийг хамгаалах үндэсний хөтөлбөр хэрэгждэг бөгөөд хохирогчийг зарим нөхцөлд энэ хөтөлбөрт хамруулна.[19] Зарчмын хувьд тус хөтөлбөрт гэрч болон мөрдөн байцаалтад оролцож буй аюулгүй байдалд нь эрсдэл учирсан бусад этгээд хамрагдах бөгөөд Гэрчийг хамгаалах үндэсний баг аюул, эрсдэлийн үнэлгээ хийж, зохих арга хэмжээг авна. Тухайлбал, нүүлгэн шилжүүлэх нь авч болох арга хэмжээнүүдийн нэг юм.

Хохирогчийг хамгаалах талаар:

Хохирогчийг хамгаалах талаар шүүхийн танхим дотор болон шүүх танхимаас гадуур хэрэгжүүлж болох хэд хэдэн хэлбэрийн хамгаалалтын арга хэмжээг хуульдаа тусгасан байна.[20] Тухайлбал, яллагдагч гэрчтэй уулзах боломжгүй буюу гэрчийг харах боломжгүй

[16] examining Magistrate – шалгагч шүүгч.
[17] Нидерландын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 190 (2) болон 284 (1) дэх хэсэг.
[18] https://www.advocatekhoj.com/library/lawreports/witnessidentityprotection/82b.php?Title=Witness%20Identity%20Protection%20and%20Witness%20Protection%20Programmes&STitle=Netherlands
[19] Dutch Decree on the Protection of Witnesses (Besluit getuigenbescherming)
[20] Нидерландын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны тухай хуулийн 226(a) to 226(f) дах хэсэг.

байдлаар шүүх хуралдааны танхимд мэдүүлэг авах арга хэмжээ багтана. Мөн шүүх хурлын танхимаас гадуур, мөрдөн байцаагч шүүгчийн[21] өмнө нэрээ нууцлан мэдүүлэг өгөх боломжтой.

Өмгөөлөгч гэрчээс байцаалт авах хүсэлт гаргаагүй тохиолдолд нэрээ нууцалсан гэрчүүдийн мэдүүлгийг нотлох баримт болгон ашиглаж болно.[22] Өмгөөлөгч нь гэрчээс байцаалт авахыг хүссэн тохиолдолд мөрдөн байцаагч шүүгч гэрчийг заналхийлэлд өртсөн гэрчийн статустай болгож болох бөгөөд энэ нь гэрчээр мэдүүлэг өгч байгаа хохирогчдод мөн хамаарна.[23] Заналхийлэлд өртсөн статустай гэрчийн хэн болохыг ерөнхийдөө өмгөөллийн талаас нууцална. Улсын яллагч, өмгөөлөгчийг заналхийлэлд өртсөн гэрчийг байцаахад оролцуулах эсэхийг мөрдөн байцаагч шүүгч буюу шалгагч магистрат шийддэг.[24] Ингэхдээ сүрдүүлэгт өртсөн гэрчийн мэдүүлгийг нотлох баримт болгон ашиглаж болох боловч яллагдагчийг шийтгэхдээ дан ганц заналхийлсэн гэрчийн мэдүүлэгт үндэслэж болохгүй.[25]

Гэрчүүдийг хамгаалах хөтөлбөрөөс гадна Нидерландад хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөр мөн хэрэгжиж байна. Энэхүү хөтөлбөрийн хувьд хохирогчид учирч болох эрсдэлийн үнэлгээг буюу хохирогчийн эрсдэлийн үнэлгээг тусад нь (гэрчийн эрсдэлийн үнэлгээнээс тусад нь) гаргаж болно. Хохирогчийг тусгайлан тохижуулсан хэсэгт (яллагдагчтай нүүрэлдэхгүй хэлбэрээр) сонсох эсвэл хохирогч болон яллагдагч хоёр нүдээр харьцахаас сэргийлэх зэрэг арга хэмжээ авч болно. Харин хохирогч насанд хүрээгүй тохиолдолд тусгайлсан тодорхой арга хэмжээ авдаг.

Хэрэгжүүлэгч байгууллагын хувьд Хууль зүйн яамны харьяа Гэрч хамгаалах үндэсний баг[26] болон Хохирогч хамгаалах баг ажиллах бөгөөд прокуророос удирдлага буюу зохион байгуулалтаар хангаж ажиллана.

БРИТАНИ

Британид гэрч, хохирогчийг хамгаалах хууль тогтоомж нь хэрэг бүртгэлтийн явцад тэдний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн олон талт арга хэмжээг тусгасан байдаг. Энэхүү систем нь гэрч, хохирогчдод хэрэгт оролцохдоо айдасгүй байх боломжийг олгож, шударга ёсыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Британи улсын хууль тогтоомжийн онцлог

- Цогц хандлага: Хамгаалалтын арга хэмжээ нь зөвхөн физик хамгаалалт төдийгүй сэтгэл зүйн тусламж, хууль зүйн зөвлөгөө, шинэ орчин бүрдүүлэх зэрэг олон талт байдаг.
- Хохирогч төвтэй хандлага: Хууль тогтоомж нь хохирогчийн эрх ашгийг хамгаалах, тэднийг хэрэг бүртгэлтийн явцад идэвхтэй оролцуулахыг дэмждэг.
- Олон салбарын хамтын ажиллагаа: Цагдаа, прокурор, шүүх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг олон салбарын мэргэжилтнүүд хамтран ажилладаг.

Британид гэрч хохирогчид үзүүлэх хамгаалалтын арга хэмжээ

- Физик хамгаалалт: Бие хамгаалагч, нууц байр, шинэ нэр өгөх зэрэг.
- Сэтгэл зүйн тусламж: Сэтгэл зүйчийн зөвлөгөө, эмчилгээ.

[21] Investigating judge буюу мөрдөн байцаагч шүүгч нь зарим төрлийн мөрдөн байцаалтын үүрэг гүйцэтгэдэг байна. Гэхдээ өөрөө мөрдөн байцаалтын арга хэмжээ авах боломжгүй бөгөөд прокуророос шаардсан тохиолдолд л ийм арга хэмжээ авна. Түүнчлэн мөрдөн байцаагч шүүгч нь улсын яллагч мөрдөн байцаах эрх мэдлийнхээ хүрээнд ажиллаж байгаа эсэхэд хяналт тавина. Үүнд, улсын яллагч нь утас чагнах, гэрт нэгжлэг хийх, урьдчилан хорих шийдвэр гаргах зэрэг арга хэмжээ авахад мөрдөн байцаагч шүүгчээс зөвшөөрөл авах шаардлагатай байна.
[22] Нидерландын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны тухай хуулийн 344(a)(3)(b)
[23] Нидерландын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны тухай хуулийн 226(a) дэх хэсэг.
[24] Нидерландын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны тухай хуулийн 226 (d) дэх хэсэг.
[25] Нидерландын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны тухай хуулийн 344(a)(1) дэх хэсэг.
[26] Witness protection unit

- Хууль зүйн тусламж: Өмгөөлөгчийн үйлчилгээ, шүүх хуралдаанд оролцоход туслалцаа үзүүлэх.
- Мэдээллийн дэмжлэг: Хэрэг бүртгэлтийн явц, хууль ёсны эрхээ хэрхэн хамгаалах талаар мэдээлэл өгөх.
- Нийгмийн дэмжлэг: Шинэ орчин бүрдүүлэхэд туслах, ажил олоход дэмжлэг үзүүлэх.

Британийн гэрч, хохирогчийг хамгаалах системийн онцлог

- Гэрч, хохирогч судлалын хөгжил: Британийн гэрч, хохирогчийн судлал гэх шинжлэх ухааны салбар хүчтэй хөгжсөн бөгөөд энэ нь хохирогчдын хэрэгцээг илүү сайн ойлгоход тусалдаг.
- Олон төрлийн байгууллагын хамтын ажиллагаа: Цагдаа, прокурор, шүүхээс гадна олон төрлийн төрийн бус байгууллагууд хохирогчдод туслалцаа үзүүлдэг.
- Хууль тогтоомжийн тогтвортой байдал: Хууль тогтоомж нь байнга шинэчлэгдэж, сайжруулагдсаар байдаг.

Британид гэрч, хохирогчийн амь нас, аюулгүй байдалд ноцтой, бодитой аюул учирсан болон заналхийлэлд өртсөн бол гэрч хохирогчийг хамгаалалтад авах эрх үүсдэг:

- **Онц ноцтой гэмт хэрэг:** Онц ноцтой гэмт хэргийн гэрч болсон бол (жишээ нь, зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодис худалдаалах, терроризм, аллага гэх мэт) танд хамгаалалт үзүүлэх магадлал өндөр байдаг.
- **Гэрчийн мэдүүлгийн ач холбогдол:** Тухайн гэрч, хохирогчийн мэдүүлэг хэргийг илрүүлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэж байвал та хамгаалалтад хамрагдах боломжтой.
- **Бодит заналхийлэл:** Гэмт хэргийн гэрч, хохирогчид шууд болон шууд бус заналхийлэл ирж байвал тухайн гэмт хэргийн гэрч, хохирогч хамгаалалтад хамрагдах эрхтэй.

Гэрч, хохирогчийн хамгаалалтад ороход:

- Цагдаагийн байгууллагад хандах: Гэмт хэргийн гэрч, хохирогчийн амь нас эсвэл аюулгүй байдалд ямар нэгэн аюул учирч байгаа талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэх хэрэгтэй.
- Нотлох баримт үзүүлэх: Гэмт хэргийн гэрч, хохирогч өөрийн болон хэргийн талаарх мэдээлэл үнэн болохыг нотлох баримт бичгийг цагдаагийн байгууллагад өгөх шаардлагатай. Тухайлбал, заналхийлсэн зурвас, дуудлага эсвэл физик хүчирхийлэлд өртсөний талаарх баримт.
- Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаалтад хамтран ажиллах: Гэмт хэргийн гэрч, хохирогчийн мэдээлэл дээр үндэслэн цагдаагийн байгууллага мөрдөн байцаалт явуулах бөгөөд тэдэнтэй идэвхтэй хамтран ажиллах хэрэгтэй.
- Сэтгэл зүйн үзлэгт орж болно: Зарим тохиолдолд гэрч, хохирогчийн сэтгэл зүйн байдлыг үнэлэх зорилгоор сэтгэл зүйн үзлэгт оруулж, нөхцөл байдлын үнэлгээ тогтооно.

Хамгаалалтын арга хэмжээ:

Хэрэв гэмт хэргийн гэрч, хохирогч хамгаалалтад хамрагдвал дараах арга хэмжээг авах боломжтой:

- Шинэ нэр, шинэ бичиг баримт олгох: Гэмт хэргийн гэрч, хохирогчийн хувийн мэдээллийг өөрчилж, шинэ нэр, шинэ бичиг баримт олгох боломжтой.
- Шинэ орон сууц олгох: Гэмт хэргийн гэрч, хохирогчийг аюулгүй газарт шилжүүлж, шинэ орон сууц олгох боломжтой.
- Цагдаагийн хамгаалалт гаргах: Гэмт хэргийн гэрч, хохирогчийг цагдаагийн хамгаалалтад авах боломжтой.

- Санхүүгийн дэмжлэг: Шинэ амьдралаа эхлүүлэхэд нь туслах санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.
- Сэтгэл зүйн тусламж: Сэтгэл зүйн байдлыг дэмжих зорилгоор сэтгэл зүйчийн тусламж үзүүлж болно.

Британид гэрч хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байгууллагууд:

- Цагдаагийн газар;
- Хуульчийн зөвлөгөө;
- Иргэний нийгмийн байгууллагууд;

Британид гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд өргөн хүрээний тусламж үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тэдний аюулгүй байдал, сэтгэл санааны эрүүл мэнд, нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг байна. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний байгууллага NSPCC (National Society for the Prevention of Cruelty to Children) үүнд голлох үүрэгтэй ажилладаг.

Үзүүлэх тусламжийн хэлбэрүүд:

- Хамгаалах:
    - Хүүхдийг аюултай орчноос холдуулах: Хэрэв хүүхэд гэртээ эсвэл өөр нэг газар хүчирхийлэлд өртөж байгаа бол түүнийг аюулгүй газар руу шилжүүлж болно.
    - Хууль хүчний байгууллагын хамгаалалт: Шаардлагатай тохиолдолд цагдаагийн хамгаалалт гаргаж өгдөг.
- Сэтгэл зүйн тусламж:
    - Сэтгэл зүйчийн зөвлөгөө: Хүүхдийн сэтгэл санааны шархыг эдгээхэд туслах сэтгэл зүйчийн зөвлөгөө өгдөг.
    - Гэр бүлийн зөвлөгөө: Тухайн хүүхдийн гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг.
- Хууль зүйн тусламж:
    - Хуульчийн үйлчилгээ: Хүүхдийн эрх ашгийг хамгаалахын тулд хуульчийн үйлчилгээг үнэ төлбөргүй эсвэл хөнгөлөлттэй үнээр үзүүлдэг.
    - Шүүх хуралдаанд дэмжлэг үзүүлэх: Хэрэг шүүхэд шилжсэн тохиолдолд хүүхдэд шүүх хуралдаанд оролцоход нь туслалцаа үзүүлдэг.
- Боловсролын дэмжлэг:
    - Сурлагын бэрхшээлийг даван туулахад нь туслах: Хүчирхийлэлд өртсөнөөс болж сурлагын бэрхшээлтэй болсон хүүхдийг тусгай хөтөлбөрт хамруулдаг.
- Нийгмийн хамгаалал:
    - Хүүхдийн хэрэгцээнд тохирсон үйлчилгээг үзүүлэх: Хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлдэг.

Эдгээр үйлчилгээг хүргэх гол байгууллагууд:

- Цагдаа: Хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хэргийг шалгадаг.
- Нийгмийн ажилтан: Хүүхэд болон түүний гэр бүлд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, шаардлагатай үйлчилгээнд холбодог.
- Сургууль: Хүүхдийн сурлагын амжилтыг дэмжиж, аюулгүй орчныг бүрдүүлдэг.
- Эрүүл мэндийн байгууллага: Хүүхдийн бие махбодын болон сэтгэл санааны эрүүл мэндийг хамгаалдаг.
- Төрийн бус байгууллагууд: Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг.

Британид хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж маш хүчтэй бөгөөд хүүхэд бүр эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих эрхтэй гэж үздэг. Хэрэв хүүхэд аливаа хүчирхийлэлд өртөж байгааг мэдсэн даруйд цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй бөгөөд эс бөгөөс тухайн иргэнд хуулийн хариуцлага тооцох заалттай байна.

ГУРАВ. ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан эрх зүйн холбогдох бусад актаас бүрдэнэ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

Энэ хуулийн зохицуулалтад гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч хамаарах[27] бөгөөд шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно[28]. Үүнд, хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно[29]. Мөн гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно[30].

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зарчмын хувьд тус хуулийн 3.2 дахь хэсэгт зааснаар гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

1) Хамгаалалтын арга хэмжээ:

Тус хуулийн 6.1 дэх хэсэгт зааснаар хамгаалалтын арга хэмжээ нь дараах 2 үндсэн төрөлтэй байна. Үүнд:

1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ;
2. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ.

Үүнээс, хуулийн 7.1 дэх хэсэгт зааснаар нийт 9 хэлбэрийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

Хүснэгт 2. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хэлбэрүүд

№	Арга хэмжээ	Тайлбар
1	Урьдчилан сануулах	Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд халдахаар заналхийлбэл тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна[31].
2	Тодорхой үйлдлийг хязгаарлах	Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна[32].

[27] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 5.1 дэх хэсэг.
[28] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 5.2 дах хэсэг.
[29] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 5.3 дах хэсэг.
[30] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 5.4 дэх хэсэг.
[31] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 8.1 дэх хэсэг.
[32] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 9.1 дэх хэсэг.

3	Биечилсэн хамгаалалт	Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна[33].
4	Мэдээллийн нууцлалыг хангах	Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн талаарх мэдээлэлд өөрчлөлт оруулах, зохиомол нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ[34]. Мөн эрх бүхий албан тушаалтан иргэний бүртгэлийн, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн болон хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргаж болно[35].
5	Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах	Гэрч, хохирогчийг Хувийн хамгаалалтын тухай хуульд заасан тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно[36].
6	Аюулгүй газарт түр байрлуулах	Шаардлагатай тохиолдолд насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна[37].
7	Нүүлгэн шилжүүлэх	Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ[38]. Нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно[39].
8	Баримт бичгийг солих	Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж, баримт бичгийг солино[40]. Баримт бичгийг солих аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд дараах баримт бичгийн өөрчлөлт хамаарна[41]. Үүнд: - иргэний болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, гадаад паспорт, гэрлэлтийн баталгаа, диплом болон бүх төрлийн зөвшөөрөл зэрэг албаны баримт бичиг; - эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цэргийн бүртгэл, эдгээртэй адилтгах нийгмийн хамгаалал, халамжтай холбоотой бусад баримт бичиг; - хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн гэрчилгээ; - хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ; - шаардлагатай бусад баримт бичиг.

[33] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 10.1 дэх хэсэг.
[34] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 11.1 дэх хэсэг.
[35] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 11.2 дах хэсэг.
[36] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 12.1 дэх хэсэг.
[37] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 13.1 дэх хэсэг.
[38] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 14.1 дэх хэсэг.
[39] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 14.2 дах хэсэг.
[40] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 15.1 дэх хэсэг.
[41] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 15.2 дах хэсэг.

9	Гадаад төрхийг өөрчлөх	Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалалтын өөр арга хэмжээгээр хангах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчилж болно[42]. Мөн гэрч, хохирогчийн гадаад төрхийг мэс заслын бус аргаар өөрчлөх /үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх гэх мэт/ хамгаалалтын арга хэмжээ авч болно[43].

Эдгээр арга хэмжээг шаардлагатай тохиолдолд хамтатган хэрэглэх бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ[44].

Харин сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна. Үүнд:

- гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах;
- гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;
- шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;
- шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;
- шаардлагатай бусад арга хэмжээ.

Гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх[45] бөгөөд сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг дээр авч үзсэн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээтэй хамт хэрэгжүүлж болно[46].

Аливаа хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгч, прокурорын бичгээр гаргасан санал байна[47]. Улмаар эрх бүхий албан тушаалтан гэрч, хохирогчийн хүсэлт, зөвшөөрөл, бодит аюул заналхийллийн талаарх баримтыг үндэслэн, нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг нэн даруй гаргана[48].

Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахдаа эрх бүхий албан тушаалтан дараах нөхцөлийг харгалзан үзнэ[49]. Үүнд:

- гэрч, хохирогчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл;
- хамгаалалтад авснаар олон нийтэд учирч болох эрсдэл;
- гэрч, хохирогчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол;
- нөхцөл байдлын үнэлгээ, аюулын эрсдэлийн түвшин;
- хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;
- хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн;
- бусад нөхцөл.

Хуульд зааснаар нөхцөл байдал, өгөгдлөөс шалтгаалан мөрдөгч болон шүүгч хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана[50].

[42] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 16.1 дэх хэсэг.
[43] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 16.2 дах хэсэг.
[44] Мөн тэнд.
[45] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 17.1 дэх хэсэг.
[46] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 17.3 дах хэсэг.
[47] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 20.1 дэх хэсэг.
[48] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 21.1 дэх хэсэг.
[49] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 22.1 дэх хэсэг.
[50] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 21.2 дах хэсэг.

2) Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага

Хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ. [51] Үүнд:

1. Цагдаагийн алба
2. Авлигатай тэмцэх газар
3. Тагнуулын ерөнхий газар

Хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ тухайн байгууллагын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна[52].

Хуульд зааснаар хамгаалалтын тусгай алба нь гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ[53]. Үүнд:

- гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шуурхай авах;
- гэрч, хохирогчийг мэдээллээр хангах;
- нүүлгэн шилжүүлэх, баримт бичиг солих, мэс заслын аргаар гадаад төрхийг өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- шинээр ажилд ороход туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах;
- хууль зүйн туслалцаа болон нийгмийн бусад туслалцаа үзүүлэх;
- шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын хамгаалалтын хэлбэрийг өөрчлөх, цуцлах тухай саналаа холбогдох албан тушаалтанд гаргах;
- гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг хамгаалах, энэ хуульд заасан туслалцаа үзүүлэх;
- хамгаалалтын үйл ажиллагааны нууцлалыг хангах;
- хамгаалалтад авсан гэрч, хохирогчийн талаар мэдээллийн сан үүсгэн хөтлөх;
- шаардлагатай бусад.

Мөн эдгээр тусгай албаны дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн баг ажиллана[54]. Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газрын хувьд хуульд заасан арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ[55].

Үүнээс гадна гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана. [56]

Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- гэрч, хохирогчийг хамгаалах салбар дундын ажлыг уялдуулан зохицуулах;
- гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх талаар санал боловсруулах, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;
- холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагад зөвлөмж өгөх;
- гэрч, хохирогчийг хамгаалах байгууллага, албадын алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;
- иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлах.

[51] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 23.1 дэх хэсэг.
[52] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 23.2 дах хэсэг.
[53] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 23.3 дах хэсэг.
[54] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 23.4 дэх хэсэг.
[55] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 23.5 дах хэсэг.
[56] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 25¹.1 дэх хэсэг

Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахалж, бүрэлдэхүүнд нь санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллага, прокурор, шүүх, холбогдох бусад төрийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж ажиллана.[57] Мөн зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.[58]

Бусад хууль тогтоомж

Бусад хууль тогтоомжийн хувьд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Төрийн болон албаны нууцын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд тус тус холбогдох зохицуулалт багтсан байна.

Тодруулбал, Эрүүгийн хуульд гэрч, хохирогчийн болон түүний ойр дотны хүнд нь хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хохирол учруулахаар сүрдүүлэх, эсхүл ятгах, шан харамж амлах, өгөх төдийгүй нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах нь гэм хэрэгт тооцогдохоор заасан.[59] Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэрч, хохирогчийг хэрхэн хамгаалах талаар зохицуулсан.[60]

Төрийн болон албаны нууцын тухай хуульд “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл”-ийг төрийн нууцад хамааруулсан [61] бөгөөд хамгаалалтад авсан хүний талаар нууцалбал зохих мэдээллийг байнга нууцална[62] гэж заасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл өгсөн этгээд гэрч, хохирогчид туслалцаа, дэмжлэг үзүүлсэн этгээдийг айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгих, дарамт, шахалт үзүүлэх, буруутгах, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглосон. [63] Мөн холбогдох албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хохирогч, гэрч, мэдээлэл өгсөн этгээдийн талаарх мэдээллийг задруулахыг хориглосон. [64]

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хувьд хохирогч төдийгүй хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлж, таслан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдүүлэг өгсөн гэрч болон уг гэмт хэргийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг хангах зорилгоор хохирогчийг хамгаалах арга хэмжээнд хамруулж болох[65] тухай заасан.

Харин Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд хүний эрх хамгаалагчийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авах[66] тухай заасан байна.

[57] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 25¹.2 дах хэсэг.
[58] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 25¹.3 дах хэсэг.
[59] Эрүүгийн хууль, 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
[60] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 13.1-13.7 дугаар зүйл.
[61] Төрийн болон албаны нууцын тухай хууль, 13.1.4.п дэх хэсэг.
[62] Төрийн болон албаны нууцын тухай хууль, 17.4 дэх хэсэг.
[63] Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 7.1 дэх хэсэг.
[64] Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 23.7 дах хэсэг.
[65] Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 14.1 дэх хэсэг.
[66] Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

АНУ

- U.S. Marshals Service https://www.usmarshals.gov/who-we-are
- U.S. Marshals Service Fact Sheet-Witness security https://www.usmarshals.gov/sites/default/files/media/document/2024-Witness-Security.pdf
- Emergency Witness Assistance Program https://oig.justice.gov/reports/EOUSA/e0102/index.htm
- Office of Enforcement Operations https://www.justice.gov/criminal/criminal-oeo
- Office for Victims of Crime https://ovc.ojp.gov/about/what-is-ovc-fact-sheet.pdf
- Victim/Witness assistance program https://www.justice.gov/usao-cdca/programs/victimwitness-assistance-program
- FBI Victim Services https://www.fbi.gov/how-we-can-help-you/victim-services
- Victim Services agencies https://www.justice.gov/agencies/chart/grid#victim-services
- National Center for Victims of Crime https://victimsofcrime.org/about/

ГЕРМАН

- Rights and obligations of witnesses, https://www.hilfe-info.de/Webs/hilfeinfo/EN/KnowYourRights/HilfeUndRechte/witnesses/RechteUndPflichten/RechteUndPflichten_node.html#:~:text=In%20certain%20cases%2C%20witnesses%20may,or%20relatives%20by%20doing%20so.
- Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime, United Nations Office on Drugs and Crime, Vienna https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf
- Organized crime / witness protection in germany, Johan Peter Wilhelm Hilger, https://www.unafei.or.jp/publications/pdf/RS_No58/No58_12VE_Hilger3.pdf
- German Code of Criminal Procedure, https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html
- Victim protection and victim support, https://www.berlin.de/zentrale-anlaufstelle/justizielle-opferhilfe/artikel.873423.en.php

НИДЕРЛАНД

- Dutch Criminal Code of Proceedings (Wetboek van Strafvordering).
- Witness Protection Act of Netherlands
- https://www.advocatekhoj.com/library/lawreports/witnessidentityprotection/82b.php?Title=Witness%20Identity%20Protection%20and%20Witness%20Protection%20Programmes&STitle=Netherlands

БРИТАНИ

- Domestic Violence, Crime and Victims Act 2004 (UK), 2018 c 28
- United Nations (‘PJVC’) (1985) The Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power, resolution GA/RES/40/34 of the General Assembly; 29 Nov 1985. See also UN
- National Child Protection Authority (NCPA)

- https://assets.publishing.service.gov.uk/media/60620279d3bf7f5ceaca0d89/victims-code-2020.pdf
- https://www.nationalarchives.gov.uk/doc/open-government-licence/version/3/
- https://www.gov.uk/official-documents
- The Victims' Code is issued by the Secretary of State for Justice under section 32 of the Domestic Violence, Crime and Victims Act 2004

Хууль тогтоомж:

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013 он
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012 он
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2021 он
- Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016 он
- Эрүүгийн хууль, 2015 он
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

Олон улсын гэрээ, конвенц:

- Convention against torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment
- Declaration of basic principles of justice for victims of crime and abuse of power
- Optional protocol to the convention on the rights of the child on the involvement of children in armed conflict
- Rome statute of the international criminal court
- United Nations convention against transnational organized crime